

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Банзарын Шаравнамжил	Дугаар	L035
Оршин суугаа аймаг	Төв	Оршин суугаа сум	Зуунмод
Төрсөн газар	Дундговь аймгийн Цагаандэлгэр сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баруун Чойр	Сүм хийдийн дугаар	ДУЦД 071
Одоогийн сүм хийд	Төв аймгийн Манзушир хийд	Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Баруун Чойр

Боржигон Жанжин бэйлийн хоёр их том чойр байсан, 1000 гаруй, 1000 гаруй ламтай. Би түүний Баруун дээр нь байсан хүн. Эцгийнхээ өврөөс гараагүй зургаахан настай байхдаа тэнд очсон. 5,6 жил ном сурч уншлага номоо төгсгөж байж лам болдог юм. Одоотой адил би лам болно гээд л болчихгүй. Тэнд би 18,19 хүртлээ шавилан суусан. 1937 онд их хэлмэгдэлт болж байлаа тэр үед яаж лам байх вэ дээ, хар болсон.

Баруун Чойр гэдэг нь долоон дугантай. Цогчэн, Манба, Ламрим, Цам, Зурхай, Чойр гэсэн дугануудтай. Эд тус бүрт нь 300 гаруй шавь нартай. Баруун Чойр, Зүүн Чойр хоёр нь хоорондоо 30 км зайтай. Ундарга зандан ширээ гэж нэрлэгдсэн газар. Зандан гэж уул бий. Их далайг тахидаг. Хойноо Шивээ гэж толгойтой. Одоо тэнд Чойр дуганын суурин дээр суварга босгосон байгаа. 1990 он гараад тэнд сууж байсан өвгөчүүд нийлээд нэг хурал гаргасан. Цагаандэлгэрийн хийд гэж одоо нэг хийд байгаа. Үргэлжийн хурал байхгүй. Өвгөчүүл бурхан

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болоод. Жил бүр 9 сар гараад сахиусаа тахина гэж хурал хурна. Тал бүрээс над мэтийн ганц нэг хүн цуглаад. Одоо ч очдог ч хүнгүй болж байна даа.

Баруун чойр нь Боржигоны хошуу гэж байсан. Хошуу ноён нь Гомбосүрэн ноён гэж байсан. Чойр зун болохлоор асад долоон отог гэж долоон салбартай байсан юм. Тэрийг нь хөдөө жас нар гэж нэрлэдэг байсан. Тулга, цээжний, уут, ухаат, зүүн, баруун Чойжин, ловон жас гэсэн долоон хөдөөгийн жас нар байсан. Тэр жасууд зуны хуралтай. Баруун Чойрын лам нар очно. Одоогоор бол 45 хоногийн амралт юм даа. Тэр амралтаараа жас дээр байж хурал хурна. Тэгээд очиж хурахад зүгээр нэг давхиад очихгүй. Эвт орсон хүн очно. Эвт ороогүй лам бол хурахгүй. Эвт яаж орох вэ гэхлээр нэг ишиг, төлөг өгнө. Тэгээд тэр хуралд хурах эрхээ олж авна. Сангууд их баян. Хурал дээрээ гүү малаа барьчихна. Нэг жас 6-7 хоног хурна. Өө би Уутаг эв байхгүй, тулга жасад эв байхгүй гээд хурахгүй.

Хийдийн гол шүтээн нь Хандам байсан. Тэр Хандамыг аваад үлдсэн байж байгаад хожим Ганданд өгсөн. Авч үлдээд айлын байшинд нууцаар хадгалж байсан юм. Гол Ядам нь Хандам байсан. Бүх дацан тус тусдаа өөр сахиустай. Эмийн дацан Манлыг шүтэж байсан.

1000 гаран ламтай байсан юм. Сан ихтэй. 500, 600-аад мянга шахам адуутай. Тэгээд хонь мал олонтой. Их том жастай байсан юм. Хурлын бүх хэрэгслийг гаргана. Жандаг байхгүй үед жасаасаа хурлын хэрэгслийг гаргана. Гурилын нярав, будааны нярав гээд тус тусдаа байсан. Дацангууд нь тус тусдаа жастай. Хамгийн том нь Цогчэн жас байсан. Тэгээд Чойр жас орно. Жасын мал тусгай айл дээр байдаг. Намар болохоор адуугаа гаднаа авчирна. Энэ чинь юу гэхлээр Чойр жасын адуу гэнэ. Адууны хар хомоол гэж их сайхан түлш болно. Тэрийг нь хэрэглэх гэж тэгж ойртуулж байсан. Жас их баян. Олон шар тэрэгтэй. Тэгээд зиндаа зиндааныханд үүрэг өгөөд аргал түүлгэнэ. Хоёр анги аргал түүнэ гэвэл хорь гучин шар тэрэг хөллөөд тэгээд түлшээ татаад авчихна. Хүнээс гүйх юм байхгүй.

Ловон хувилгаан гэж байсан. 10-аад жилийн өмнө 100 жилийн ой нь болсон. Лхаарамба, маарамба гэж байсан. Хийдийн хамба нь Шаравжамц гэдэг хүн байсан. Лүнгийн лам гэж нэрлэдэг байсан. Ном уншаад л лүн тавьдаг байсан юм. Их том лам байсан. Гэндэнпил, Лувсандагва, Жамъян гэж унзадууд байсан. Чойрын шунлайв нь Чүлтэмдагва гэж байсан.

Миний зиндааны Лодойжамц гэдэг хүн Чойрт байгаа. Дамбадаржаа байна. Дундговьд миний үеийн 2 өвгөн бий. Номын бар байсан. Тийм ном ингэж гаргалаа, тэгж гаргалаа гэдэг л байсан. Дутуу юм гэж байгаагүй. Баруун Чойр нь дэг журмаар их сайн.

Мамба чинь эмийн дацан. Одооны улсууд лам л бол ном мэднэ гэж бодож байна. Тус тусдаа. Эмийн хүн зурхайн номыг мэдэхгүй. Зурхайн хүн эмийн номыг мэдэхгүй.

Чойр Жанжигзүсэм гэсэн 3 номыг уншдаг байсан. Ондогжан, Уманжүг, Доодүд гэсэн. Ийм 3 номыг онцолж уншдаг байсан. Өглөө харангаа дэлсээд л хурлаа хурна. Орой ихээхэн хуралтай бол орой, багахан хуралтай бол барагтай нэг тарна. Өдөр бүр хурна. Тэр үед хурал таслах гэж огт байгаагүй. Цамтай, Майдартай байсан. Зуны цам, намрын цам гэж байсан. Майдарыг зуны дунд сарын 15-нд эргэнэ. Цамын маш олон дүр

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гардаг байсан. 2 азар, 2 гэлэн, 2 мич, 4 хохимой гээд зөндөө. Ганжуурыг зун эргэдэг. Ганжуур эргэхэд хүрээгээ тойрч эргэдэг. Нутгийн хилийн дээсээр ч явдаг байсан. Нүгнээ үргэлж 4 цагт сахина. Хайлан хурна. Дутах юм байхгүй бүгд л байна.

Би Чойрт хадаг, шидүв, дүйчэн, дүймпрэн, жумбарай, ламбирай гээд 10 гаран жил сурсан. Дом тавихын урьд шашин бүдгэрсэн. Манай зиндаа 28, 29 ламтай байсан байх. Жорвон Лүнрэг гэдэг хүн байсан. Манай дээд зиндаанд Боргио Гунгаа гэдэг хүн байсан. Одоо тэр зиндаанаас нэг ч хүн байхгүй. Манай доод талын зиндааны жорвон нь Дамбадаржаа байсан. Одоо ганцаараа үлдсэн байгаа. Дүйра 4, тэгээд дээшээ яваад дом, ум, парчин, зод, дүлба гэсэн зиндаанууд байсан. Тэгээд гавж, лхаарамба болно. Зиндаа тус бүрт нэг нэг жил сурна. Гавжийн дамжаатай. Гавжийн дамжааг жилд нэг удаа 2 лам, 3-4 хоног барина. Чойрын сургалт нь Гүнчэн ламын игчаатай байсан.

Модон дугантай, хэрмэн хашаатай, горооны замтай. Лам нар байшинтай, гэртэй янз янз. Аймаглаж суудаг байсан. Зүүн хүрээ, баруун хүрээ, зүүн хойт хүрээ, баруун хойт хүрээ гэж 4 хүрээтэй байсан.

Зулын 25-нд Баруун Чойр, Зүүн Чойр хоёр мөсөн дэнлүүнийхээ гэрлээр бие биеэ хардаг байсан. Лүйжин гэдэг нь зоч гэсэн үг. Зочийн хурал Ламрим дацанд хурдаг байсан.

Хийд 1937 онд хаагдсан. Шашны төлөөлөгч гэдэг хүн засгаас яваад. Ухуулга таниулга хийгээд. Шашны төлөөлөгч Гэлэгсэнгэ гэдэг хүн байсан. Сүүлд нь Лувсанжамъян гэдэг хүн байсан. Хийд чинь багассаар багассаар хаагдсан. Тэр үед 60 лам хүүхэд татаад. Сангийн яамны шефийн холбооны сургуульд орсон. Би сургуулиа хаяад оргочихсон юм. Би халх голын дайнд 19 настай явсан. 6 жил болоод халагдсан. Цэргээс ирээд мал малласан. Дараа нь жолооч болсон. Дундговьд 40 гаран жил амьдарсан. Тэгээд Төв аймагт ирсэн. Одоо энэ Төв аймгийн хийдэд долоо найман жил хурал хурж байна.